



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/980

Улаанбаатар хот

### Өмчийн харилцааны газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 63.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг баталсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Өмчийн харилцааны газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

3. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр албан тушаалаас чөлөөлөгдөж байгаа албан хаагчдыг Төрийн албаны тухай хууль, холбогдох хууль, журамд заасан баталгаагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1059 дүгээр захирамжийн Өмчийн харилцааны газарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110204507

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
08.09.2024 сарын 09.09. ёдрийн  
11.1980 дундаж 1 захирамжийн  
хавсралт

ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН БҮТЦЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

Д/д	Хэрэгжүүлэгч агентлагийн нэр	Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Өмчийн харилцааны газар	1.Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс; 2.Өмчийн хяналт шалгалтын хэлтэс 3.Захиргаа удирдлагын хэлтэс; 4.Хууль зүйн хэлтэс.	63 хүртэл, үүнээс Дарга-1